



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 07 өдөр

Дугаар A/04

Цагаан-Уул сум

Г

Т

Агаар бохирдуулагч эх үүсвэрийн  
тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч: Г.Одгэрэл (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)  
Гишүүд: Д.Мөнхбат (Татварын Улсын байцаагч)

Г.Жанчивдорж (Гал түймэр унтраах аврах 73 дугаар ангийн захирагч)

А.Энхбаатар (Газрын даамал)

Д.Ичинхорлоо (Улсын бүртгэгч)

Н.Жанчивдорж (Байгаль хамгаалагч)

О.Батзаяа (Эрчим хүчний монтёр)

О.Дашбямба (Жаргалант багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Мөнхчимэг (Цаг уурч)

2. Сумын төвд байнга болон түр оршин суугч өрх, үйл ажиллагаа явуулж байгаа нэгдсэн дулаанд холбогдсон аж ахуйн нэгж, айл өрхийн тоо, бүх төрлийн тээврийн хэрэгслийн тоо, хог хаягдлын цэгийн талбайн хэмжээ зэрэг утаа гаргадаг цэгийн тоо бүртгэлийг шинэчлэн гаргаж дүн мэдээг холбогдох маягтын дагуу гаргаж аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний лабориторид хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Одгэрэл), нарийн бичгийн дарга (Б.Мөнхчимэг) нарт үүрэг болгосугай.

ОРЛОГЧ ДАРГА

Н.АЛТАНБААТАР

/Zahiramj 2025/